

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Б.ЭНХБАЯР

**БАЙГАЛЬД ЗОРЧИХ, ЯВГАН АЯЛАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн", мөн зүйлийн 4 дэх хэсэгт "Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх", Арван зургадугаар зүйл, Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 18 дахь хэсэгт "Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих..." гэж тус тус заасан.

"Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны Хөгжлийн бодлогын 2.2 дахь хэсэгт "Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ", 3.6 дахь хэсгийн 1-д "Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна", 5.5 дахь хэсгийн 1-д "Хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ" гэж тус тус тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.4 дэх хэсэгт "Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ", 5.1 дэх хэсэгт "Байгаль орчныг хамгаалах, ...иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ" гэж тус тус заасан.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.18 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхтэй гэж заасан. Энэ эрх нь иргэд хуулиар хориглоогүй бүхий л газар түүний дотор эх орныхоо байгалийн сайханд аялах, зугаалах, амрах эрхийг баталгаажуулсан зохицуулалт юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын тухай хуульд бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалаагүй бол хэн боловч тухайн газарт хохирол учруулахгүйгээр нэвтэрч, дайран өнгөрч болно гэж заасан байдаг. Гэтэл бодит байдал дээр иргэдийн зорчих, байгалийн сайханд аялах эрх зөрчигдөх нөхцөл үүсээд байна.

Улаанбаатар хот болон бусад төв суурин газрын агаарын бохирдол хүн амын эрүүл мэнд, амьсгалын болон зүрх судасны тогтолцооны өвчлөлд голлон нөлөөлөх хүчин зүйл болоод байна. Агаарын бохирдолоос гадна дэлхий нийтэд тарсан шинэ төрлийн коронавирүсээр Монгол Улсад 466 мянган хүн халдвар авснаас 2100 орчим хүн нас бараад байна. Халдвар авсан хүмүүсийн нөхөн сэргээлтэнд агаарын чанарын асуудал чухал нөлөөтэй байдаг.

Иргэд өвлийн улиралд зуслангийн ногоон бүс болох Хандгайт, Нүхт, Шарга морьт, Гүнт орчимын ууланд гарах, цана чаргаар гулгах, ойр орчимын ой модонд алхах зэргээр цэвэр агаарын хэрэгцээгээ хангаж байна. Гэтэл зуслангийн бүс орчимд төлөвлөлтгүй олгосон газар, иргэд зуслангийн хашаа барихдаа орц гарцыг хааж, олгосон газрын хэмжээг томсгож хашаа барьдгаас шалтгаалж зуслангийн бүсийн ой мод, ууланд гарах боломжгүй нөхцөл бий болоод байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг байгалийн үзэсгэлэнт унаган төрхийг нь хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх Улсын Их Хурлын 1993 оны 83 дугаар тогтоол, Засгийн газрын 1994 оны 9 дүгээр тогтоолоор улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд авсан байдаг. Өнөөдрийн байдлаар Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт амралт, жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна. Жуулчны бааз, амралтын газрууд уулын ам, голын тохойг бүхэлд нь хааж, хашаа барьдаг байдал түгээмэл болсон. Энэ нь зөвхөн тухайн амралтын газар амарч байгаа иргэд ашиглах боломжтойгоос гадна тухайн газраар дамжин цааш зорчих, явган аялах иргэдийн эрхийг зөрчиж байгаа юм.

Иргэдийн зорчих, явган аялах эрхийг хязгаарлах байдал зөвхөн Улаанбаатар хотоор зогсохгүй хүн амтай ихтэй сум суурин газруудаас гадна байгалийн үзэсгэлэнт газруудад түгээмэл болж байгаа нь анхаарал татаж байна. Газрын тухай хууль тогтоомжинд бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөх талаар зохицуулалтыг орхигдуулсан нь нийт иргэдийн эрх ашгийг хохироох нөхцөл болжээ.

Нөгөө талаар иргэд байгальд зорчих, явган аялахдаа газар, газрын хөрс, хэвлий, ус, ургамал, амьтан, агаар болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, байгаль орчиныг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх үйлдэл /эс үйлдэхүй/ гаргахгүй байхыг тусгайлсан хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзлээ. Байгальд зорчих, явган аялах эрх нь нэг талаас Үндсэн Хуулиар олгогдсон эрх бөгөөд хүний эрүүл мэндийн хувьд чухал ач холбогдолтой боловч цаг агаарын эрс тэс уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан газрын доройтол, цөлжилт нэмэгдэж байгаа эмзэг экосистемтэй, ойн нөөц багатай манай улсын хувьд орхигдуулж болохгүй асуудал юм. Өөрөөр хэлбэл хуулиар олгогдсон эрхээ эдлэхдээ хариуцлагын асуудлыг давхар тусгах шаардлагатай юм.

Байгальд зорчих, явган аялах эрхийг хэт өргөн хүрээнд авч үзэж, хүссэн газраа, хүссэн үедээ зорчих, аялах нь байгалийн унаган төрхийг алдагдуулах эрсдэлтэй тул тодорхой газруудад, тодорхой цаг хугацаанд зорчих, явган аялахыг хориглох талаар хуулийн төсөлд тусгасан. Судалгаанд хамрагдсан улс орнууд байгальд зорчих, явган аялах гэдэгт механикжсан тээврийн хэрэгслээр аялахыг хориглодог бөгөөд явганаар, дугуйгаар, морь буюу ердийн хөсгөөр зорчихыг хамруулдаг нийтлэг зохицуулалттай байсан тул энэ зохицуулалтыг авч хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Энэ хуулийн төслийн зорилго нь иргэд хуулиар хориглоогүй бүхий л газар, түүний дотор эх орныхоо байгалийн сайханд чөлөөтэй зорчих, явган аялах эрхийг эдлүүлэхтэй холбогдуулан газар өмчлөгч, ашиглагч, эзэмшигч болон төрийн эрх бүхий байгууллага, иргэдийн эрх үүргийг тодорхойлоход оршино.

Байгальд зорчих, явган аялах эрхийн тухай хуулийн төслийн зохицуулах харилцааг тусгайлсан хуулиар зохицуулж байгаагүй тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөл боловсруулна.

Хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байна.

Нэгдүгээр бүлэгт, хуулийн зорилт, байгальд зорчих, явган аялах эрхийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт, иргэдийн байгальд зорчих, явган аялах эрх, үүргийг тодорхойлно.

Гуравдугаар бүлэгт, төрийн эрх бүхий байгууллагын эрх, үүргийг тодорхойлно.

Дөрөвдүгээр бүлэгт, газар өмчлөгч, ашиглагч, эзэмшигчийн эрх, үүргийг тодорхойлно.

Тавдугаар бүлэгт, хууль зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Байгальд зорчих, явган аялах эрхийн тухай хуулийн төсөл батлагдснаар нийгэм, эдийн засгийн дараах эерэг үр дагаврууд бий болно:

- Иргэд хуулиар хориглоогүй бүхий л газар түүний дотор эх орныхоо байгалийн сайханд зорчих, явган аялах эрх баталгаажна;
- Байгальд зорчих, явган аялахдаа газар, түүний хөрс, газрын хэвлий, ус, ургамал, амьтан, агаар болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, байгаль орчиныг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх үйлдэл /эс үйлдэхүй/ гаргахгүй байх нөхцөлийг бий болгоно;
- Иргэдийн байгальд зорчих, явган аялах эрхийг хангахын зэрэгцээ байгалийн унаган төрхийг хамгаалах хүрээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч болон төрийн эрх бүхий байгууллагын чиг үүрэг тодорхой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай /Газрын ерөнхий хууль/, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуультай уялдуулсан байна.

Энэ хуулийн төсөлтэй уялдуулан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хуулийн төсөл боловсруулна.